




DCERT

DATACENTER EMERGENCY RESPONSE TEAM

ХАЛДЛАГАД ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ БАГ

Ганц тэмдэгт бүхий зурвас “Apple iPhone, iPad болон Mac” -ыг гэмтээж болно!!!



Ганцхан тэмдэгт бүхий зурвас таны “iPhone”-ыг доголдуулж чадах ба “iOS” систем дээр түгээмэл хэрэглэгддэг “WhatsApp, Facebook Messenger, Outlook, Gmail” гэх мэт аппликейшнүүдийг ажиллагаагүй болгоно.

Хамгийн анх Италийн “MobileWorld” блог тус алдааг илрүүлсэн бөгөөд ганцхан “iPhone” гэлтгүй “Apple”-ийн өргөн хэрэглэгддэг “iPad, Macbook, Applewatch” гэх мэт бүх төхөөрөмжүүд дээр хамгийн сүүлийн үеийн системийн шинэчлэл (update) хийгдсэн ч тус алдаа нь гарч байжээ.

“Text Bomb” төрлийн энэхүү шинэ алдааг хүн болгон ашиглах боломжтой бөгөөд ашиглахын тулд хэрэглэгч “Telugu” (Энэтхэгийн эртний хэл ба одоо 70 сая хүн

хэрэглэдэг) хэлний “А” үсгийг л илгээхэд хангалттай юм. Хүлээн авагч нь энэхүү үсгийг агуулсан энгийн зурвасыг хүлээн аваад нээхэд л “iPhone, iPads, Macs, Applewatch, Apple TV” зэрэг бүх төхөөрөмжүүдэд түр хугацаанд доголдол үүсдэг байна.

Ажиллагаа:

Хүлээн авах аппликейшн нь үсгийг таних гэж оролдох боловч амжилтгүй болон үндсэн функц рүү буцах ба энэхүү үйлдэл нь тус үсгийг агуулсан харилцан зурвас устгагдах хүртэл зогсолтгүй давтагдах юм.

Telugu Character



Үүнийг зогсоох хамгийн энгийн арга бол гацаж буй аппликейшн рүү өөр хэн нэгнээс зурвас илгээн ирсэн зурвасны мэдэгдлээр дамжин гацааж буй тэмдэгт орсон зурвасыг бүхлээр нь устгах юм. Энэхүү тэмдэгт нь “iMessage, Slack, Facebook Messenger, WhatsApp, Gmail” зэрэг аппликейшнүүдийг ч мөн гацаах боломжтой. Харин “Telegram” болон “Skype” ашигладаг хэрэглэгч нарт энэхүү хортой зурвас нөлөөлөөгүй байна.

“Apple” компани энэхүү алдааг засаж эхэлсэн ба энэ хавар гарах “iOS 11.3” хувилбар дээр бүрэн засахаар төлөвлөж байгаа бөгөөд энэхүү хувилбарын туршилтын хувилбар “iOS 11.3” дээр засагдсан байхаар төлөвлөжээ.

Маш олон аппликейшн энэхүү зурваснаас шалтгаалан гацсан ба хорлон сүйтгэгч нар “Apple”-ын хэрэглэгчдийг бай болгон уг тэмдэгтийг агуулсан зурвасыг цахим шуудан болон нийгмийн сүлжээгээр дамжуулан цацсаар байна !!!

Эх сурвалж : <https://thehackernews.com/2018/02/crash-iphone-text.html>

2018.3.07